




Жендэрийн эрх тэгш байдлыг хангах мэргэжилтэн, манлайлагчдын клубын III чуулга уулзалт

А.Нарантуяа, Клубын орон нутаг хариуцсан зохицуулагч, Дундговь аймгийн
ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

(Улаанбаатар хот, 2020 оны 1-р сарын 21-ний өдөр)

Агуулга

- Клубын 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө
- Төлөвлөгөөний биелэлт
- Бэрхшээл сургамж
- Цаашид хэрэгжүүлэх санал



**Жендэрийн эрх тэгш байдлыг хангах манлайлагч, мэргэжилтний клубын
2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт**

Клубын алсын хараа: Төрийн бүх шатанд жендэрийн мэдрэмжтэй байдлыг хэвшүүлэн, төлөвшүүлэхэд түүчээлнэ.

Зорилго: Төрийн байгууллагын жендэрийн хэвшмэл ойлголт, хандлага өөрчлөгдөж, жендэрийн эрх тэгш байдлыг хангахад хувь нэмэр оруулна.



№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хэрэгжих хугацаа	2020 оны биелэлт	Хувиар	Хэрэгжилтийг хариуцах хүн
Зорилт 1. Жендэрийн клубын гишүүдийн ур чадвар сайжирч, клубын үйл ажиллагаа тогтворжсон байна.		Сургагч багш нарын хүргэсэн хичээл, тоо	0	2	Жилдээ	0	0	MERIT, Клубын 2020 оны зохицуулагчид
		Илтгэх ур чадвар сайжирсан гишүүдийн тоо, хүйсээр	0	5	Жилдээ	11	100%	MERIT, Клубын 2020 оны зохицуулагчид
		Хамтарч хэрэгжүүлсэн үйл ажиллагааы төрөл, тоо	0	3	Жилдээ	3 (Дорнод, Дундговь, 14-р сургууль)	100%	MERIT, Клубын 2020 оны зохицуулагчид
1.	Жендэрийн сургагч багш бэлтгэх (Анхан болон дунд шатны сургалт)	Сургалтад хамрагдсан гишүүдийн тоо, хүйсээр	5	10	3-4-р улирал	0	0	ЖҮХ, MERIT, Клубын 2020 оны зохицуулагчид
2.	Дэйл Карнеги төвийн “Хүчирхэг илтгэл” сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан гишүүдийн тоо, хүйсээр	14	28	1, 2-р улирал	15	100%	MERIT, Дэйл Карнеги Трэйнинг, Клубын 2020 оны зохицуулагчид
3.	Сайн туршлага судлах, сургалтад хамрагдах - Ижил төстэй гадны клубуудтэй холбогдох - Бусад төсөл, олон улсын байгууллагуудтай холбогдох, танилцах, туршлагаа хуваалцах	Сургалтад хамрагдсан гишүүдийн тоо, хүйсээр	2	3	1-4-р улирал	1	100%	MERIT, ГГХ, Клубын 2020 оны зохицуулагчид
4.	Багийн ажиллагааг бэхжүүлэх дасгал ажил /зумба/	Сургалтад хамрагдсан гишүүдийн тоо, хүйсээр	0	10	1-4-р улирал	0	0	4 аймгийн ЗДТГ, MERIT, Клубын 2020 оны зохицуулагчид
5.	Газарзүй, гео-экологийн хүрээлэнгийн Жендэрийн клубын туршлагатай танилцах, мод үржүүлгийн газарт нь очиж мод тариалалт хийх	Сургалтад хамрагдсан гишүүдийн тоо, хүйсээр	0	15	2-р улирал	21	100 %	ГГХ, ЦУНБХТ, MERIT, Клубын 2020 оны зохицуулагчид


6.	"Жендэр ба хүрээлэн буй орчин" сэдвийн хүрээнд мод тарих, хэлэлцүүлэг зохион байгуулах (Дундговь аймагт)	Суулгасан тарьцын тоо	0	100	2 улирал	200 /Дундговь дэд клуб/	100 %	ГГХ, ЦУНБХТ, MERIT, Клубын 2020 оны зохицуулагчид
7.	Орон нутагт Жендэрийн клубын гишүүдийн тоог нэмэгдүүлэх, клубын үйл ажиллагааг өргөжүүлэх	Шинээр клубт элссэн гишүүдийн тоо	6	10	2-4-р улирал	21	100 %	Дундговь аймгийн ЗДТГ
8.	Сүхбаатар аймагт 3 дахь удаагийн чуулга уулзалт зохион байгуулах - Клубын дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулан, батлах	Арга хэмжээ	1	1	12-р сар			Бүх гишүүд
Зорилт 2: Жендэрийн тэгш байдлын талаарх төрийн албан хаагчид болон олон нийтийн ойлголт сайжирсан байна.		Жендэрийн талаарх мэдлэг сайжирсан хүний тоо, хүйсээр /арга хэмжээ бүрийн дараа оролцогчдоос асуумжаар судалгаа авна/	0	100	Жилдээ			MERIT, Клубын 2020 оны зохицуулагчид
1.	"Жендэрийн дүн шинжилгээ" сургалт явуулах	Сургалтын тоо	1	6	3-4-р улирал	14	100 %	Төрийн захиргааны төв байгууллага 1, 4 аймгийн ЗДТГ, MERIT, ЖҮХ-ноос бэлтгэгдсэн сургагч багш нар
		Сургалтад хамрагдсан хүний тоо, хүйсээр	38	88		886	100 %	
2.	Хүүхэд, залуучуудад мэдлэг олгоход чиглэсэн ярилцлага, сургалт зохион байгуулах /Сэдэв: жендэр, хүний эрх, мэргэжил сонголт/ (УБ хотын 14-р сургууль, 4 аймаг бүр 1 сургууль)	Багш, сурагчдын тоо, хүйсээр	1 сургуулийн 180 гаруй хүүхэд	6 сургуулийн 680 хүүхэд	1, 4-р улирал	6 сургууль 235 Дундговь		БСШУСЯ-ны жендэрийн салбар зөвлөл, 4 аймгийн ЗДТГ, MERIT, ХЭҮК, Клубын 2020 оны зохицуулагчид
3.	Олон улсын Жендэрийн талаарх сайн туршлагыг түгээх (Канадын ЭСЯ-ны "Жендэрийн чиглэлээр ажилладаг донорын санхүүжилттэй төслүүд хоорондын ажлын уялдааг хангах" уулзалтуудад оролцох)	Семинарт хамрагдсан гишүүдийн тоо, хүйсээр	1 арга хэмжээ Оролцогчдын тоо 32	2 арга хэмжээ Оролцогчдын тоо 62-72	1, 4-р улирал			MERIT-ийн 1 зөвлөх, Клубын 2020 оны зохицуулагчид
4.	Төрийн албан хаагчдад "Жендэрийн эрх тэгш байдал ба хүний эрх" сургалтыг клубын гишүүдээр дамжуулан зохион байгуулах	Сургалт зохион байгуулсан байгууллагын тоо	0	2		2		Жендэрийн клубын гишүүд (4 аймаг, УУХҮЯ, АМГТГ)

		Сургалтад хамрагдсан сумдын тоо	0	8				
		Сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдын тоо	0	120				
Зорилт 3. Жендэрийн мэдрэмжтэй бодлого, хөтөлбөрийн баримт бичиг батлагдсан байна.		Боловсруулж, батлуулсан бодлого, хөтөлбөрийн тоо	0	2	Жилдээ			MERIT, Клубын 2020 оны зохицуулагчид
1.	Дотоод журамд дүн шинжилгээ хийх, зохих өөрчлөлтийг оруулах	Хийсэн дүн шинжилгээний тоо	0	1 байгууллага	1-4-р улирал		100 %	Дорнод аймгийн ЗДТГ
2.	Менторшип (зөвлөн туслах үйл ажиллагаа) өгөх	Зөвлөн туслах үйл ажиллагаа үзүүлсэн хүний тоо, хүйсээр	0	10	1-4-р улирал			Бүх гишүүд
3.	Ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх асуудлыг төрийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусгуулах, түүнд дүн шинжилгээ хийх	Хөдөлмөрийн дотоод журамд тусгасан байгууллагын тоо	2	10	1-4-р улирал		100 %	Дундговь аймгийн жендэрийн клубын гишүүд
4.	Төв аймгийн зарим төрийн байгууллагад ISO чанарын стандартыг жендэрийн мэдрэмжтэйгээр нэвтрүүлэхэд зөвлөн туслах	ISO нэвтэрсэн байгууллагын тоо	0	2	1-4-р улирал		100 %	Төв аймгийн ЗДТГ

Төлөвлөгөөний биелэлт



ОЙЖУУЛАЛТ 2005 - 2020 ОН



Зорилт 1: Жендэрийн клубын гишүүдийн ур чадвар сайжирч, клубын үйл ажиллагаа тогтмолжсон байна.

Үйл ажиллагаа 1.5. “Газар зүй, гео-экологийн хүрээлэнгийн Жендэрийн клубын туршлагатай танилцах, мод үржүүлгийн газарт нь очиж мод тарихад суралцах

Дэлхий нийтэд Ковид-19 өвчний цар тахал дэгдсэнтэй холбоотой орон нутгаас Улаанбаатар хотод очин ажиллах боломж бүрдээгүй хэдий ч “Газар зүй, гео-экологийн хүрээлэнгийн Жендэрийн клубын гишүүн Батдоржтой цахимаар холбогдон мод тарих арга техникийн талаар сургалт зөвлөгөөг 2 удаа авч говийн хөрсөнд ургаж болох, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд ач холбогдол бүхий мод бут, сөөгийг тарих талаар үнэтэй зөвлөмжүүдийг авч дэмжигдсэн.



Төлөвлөгөөний биелэлт



Зорилт :1. Жендэрийн клубын гишүүдийн ур чадвар сайжирч, клубын үйл ажиллагаа тогтмолжсон байна. Үйл ажиллагаа:1.6. “Жендэр ба хүрээлэн буй орчин” сэдвийн хүрээнд мод тарих, хэлэлцүүлэг зохион байгуулах (Дундговь аймагт)

Жендэрийн дэд клуб байгуулагдаж, анхны уулзалтаа 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулав. Оролцогчид MERIT төслийн жендэрийн чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай танилцаж, "Жендэрийн клуб"-ийн идэвхтэй гишүүн байгууллага болох Газарзүй-геоэкологийн хүрээлэнгээс бэлэглэсэн 200 гаруй тэхийн шээгийг суулгаж, жендэрийн төгөл бий болгох ажлын суурь тавигдав.



Төлөвлөгөөний биелэлт



Зорилт 1: Жендэрийн клубын гишүүдийн ур чадвар сайжирч, клубын үйл ажиллагаа тогтмолжсон байна. Үйл ажиллагаа: 1.7. Жендэрийн клубын гишүүдийн тоог нэмэгдүүлэх, клубын үйл ажиллагааг өргөжүүлэх

Дундговь аймаг: Бид 2019 онд 6 гишүүнтэй байсан. 2020 онд 21-үүлээ болж дэд клуб байгуулан өргөжсөн. Тус клубын гишүүнд 10 төрийн байгууллагын төлөөлөл, төрийн бус байгууллагын 2 төлөөлөл багтаж байна. Аймгийн эмэгтэйчүүдийн холбооны дарга болон хүний эрхийн орон нутаг дахь төлөөлөгч багтаж байгаа нь жендэрийн тухай ойлголтыг нэмэгдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой болж, сургалт сурталчилгааг хамтран зохион байгуулах, нөлөөллийн ажлыг хийхэд дэмжлэг үзүүлж байна.

Дорнод аймаг: 18 гишүүнтэй боллоо. Үүнд 11 байгууллагын төлөөлөл багтаж байна.

Төв аймаг: 10 гишүүнтэй боллоо.

Сүхбаатар аймаг: 20 гишүүнтэй боллоо.


Төлөвлөгөөний биелэлт



Зорилт 2. Жендэрийн тэгш байдлын талаарх төрийн албан хаагчид болон олон нийтийн ойлголт сайжирсан байна.

Үйл ажиллагаа 2.1. Жендэрийн дүн шинжилгээ сургалт явуулах

Дорнод аймаг



Нийт 492 Төрийн албан хаагчид “Ахисан түвшний жэндэрийн дүн шинжилгээ” цахим сургалтын урт ба богино хувилбаруудыг ажиллаж, 355 төрийн албан хаагч сертификат авсан.

Сургалт №1: Жендэр, жэндэрийн эрх тэгш байдлын үндсэн ойлголт

Аймаг	Эмэгтэй	Эрэгтэй	NA	Нийт
Хамрагдсан				
Дорнод	284	36	8	328
Сертификат авсан				
Дорнод	204	26	0	230

Сургалт №2: Ахисан түвшний жэндэрийн дүн шинжилгээ

Аймаг	Эмэгтэй	Эрэгтэй	NA	Нийт
Хамрагдсан				
Дорнод	146	16	2	164
Сертификат авсан				
Дорнод	114	11	0	125


Сургуулийн бүх нийгмийн ажилтнууд, багш нар, цэцэрлэгийн эрхлэгч, багш нар

Дундговь аймаг



Аймгийн төрийн байгууллагуудын хүний нөөцийн клубын гишүүд болох нийт 15 Төрийн албан хаагчид “Ахисан түвшний жендэрийн дүн шинжилгээ” цахим сургалтад хамрагдаж, 13 албан хаагчид сертификат авсан.

Аймаг	Эмэгтэй	Эрэгтэй	NA	Нийт
Хамрагдсан				
Дундговь	14	1		15
Сертификат авсан				
Дундговь	12	1		13




Төв аймаг



Нийт 81 Төрийн албан хаагчид “Ахисан түвшний
жендэрийн дүн шинжилгээ” цахим сургалтад
хамрагдаж, 58 албан хаагчид сертификат авсан.

- Бүх сумдын ЗДТГ-ын дарга нар
- Агентлагуудын дарга нар
- Нийгмийн ажилтнууд

Аймаг	Эмэгтэй	Эрэгтэй	NA	Нийт
Хамрагдсан				
Төв	50	31		81
Сертификат авсан				
Төв	40	18		58




НҮҮР ХҮҮДАС СУРГАЛТ

© Copyright Ахисан түвшний ЖДШ+ 2020

Powered By Thinkific

Сүхбаатар аймаг



Нийт 90 Төрийн албан хаагчид “Ахисан түвшний жөндөрийн дүн шинжилгээ” цахим сургалтад хамрагдав.

Аймаг	Эмэгтэй	Эрэгтэй	NA	Нийт
Хамрагдсан				
Дорнод	146	16	2	164
Сертификат авсан				
Дорнод	114	11	0	125

Ажлын байрыг жөндөрийн мэдрэмжтэй болгох, иргэнийг ажилд авахад жөндөрээр ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх тухай заалтыг аймгийн Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн хэлэлцээрт тусгахаар харилцан тохироод байна.

Төлөвлөгөөний биелэлт



Зорилт 2. Жендэрийн тэгш байдлын талаарх төрийн албан хаагчид болон олон нийтийн ойлголт сайжирсан байна
Үйл ажиллагаа 2.2. Хүүхэд залуучуудад мэдлэг олгоход чиглэсэн ярилцлага, сургалт зохион байгуулах / Сэдэв: Жендэр, хүний эрх, мэргэжил сонголт/

1. Дундговь аймаг: “Миний дуртай мэргэжил” автобустай өртөөчилсөн аялал зохион байгуулж, цаашид Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд суралцаж, нарийн мэргэжил эзэмших хүсэлтэй ерөнхий боловсролын “Хүмүүнлэг” сургуулийн 9-р ангийн 26 сурагч, “Говийн ирээдүй цогцолбор” сургуулийн 25 сурагчийг хамруулан, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Онцгой байдлын газар, Нэгдсэн эмнэлэг, Мэргэжил сургалтын үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагаатай танилцуулж, ажил мэргэжлийн онцлог шинж, давуу тал, байгууллагын бүтэц зохион байгуулалтын талаар ойлголттой болгож, бодит орчинтой нь танилцуулсан нь аяны хүрээнд хийгдэж байгаа ажлуудаас шинэлэг, хүртээмжтэй байсан нь давуу тал боллоо.



Төлөвлөгөөний биелэлт



Зорилт 2.2. Хүүхэд залуучуудад мэдлэг олгоход чиглэсэн ярилцлага, сургалт зохион байгуулах / Сэдэв: Жендэр, хүний эрх, мэргэжил сонголт/

1. Дундговь аймаг: Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн С. Бямбамаа ерөнхий боловсролын сургуулийн 50 сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг зохион байгууллаа.
2. Цар тахлын үед хөл хорионд байгаа оюутан сурагчид болон иргэдийн дунд “Миний ирээдүйн ажил мэргэжил” цахим ИЛТГЭЛ-ийн уралдаан зохион байгууллаа. 18-22 насны ангилалд АШУИС-ийн оюутан З.Анударь, 23-25 насны ангилалд Тэнгэрийн Тэмдэг Хүүхдийн театрын багш А.Дэлгэрмаа нар шалгарсан.



Төлөвлөгөөний биелэлт



Зорилт 2. Жендэрийн тэгш байдлын талаарх төрийн албан хаагчид болон олон нийтийн ойлголт сайжирсан байна.

Үйл ажиллагаа 2.2: Хүүхэд, залуучуудад мэдлэг олгоход чиглэсэн ярилцлага, сургалт зохион байгуулах /Сэдэв: жендэр, хүний эрх, мэргэжил сонголт/ (УБ хотын 14-р сургууль, 4 аймаг бүр 1 сургууль)

Дундговь аймаг: Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад “Хүүхдийн эрх болон хэрэгцээ ба хүсэл” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Энэ нөлөөллийн үйл ажиллагааны хүрээнд Сайнцагаан сумын Ерөнхий боловсролын Говийн ирээдүй цогцолбор сургуулийн 7 дугаар ангийн "Хүүхдийн эрх ба хамгаалал", "Хэрэгцээ ба хүсэл" сэдэвт сургалтыг тус бүр 2 удаа буюу 2 цагийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтад нийт 62 сурагч хамрагдлаа.

Төлөвлөгөөний биелэлт



Зорилт 2. Жендэрийн тэгш байдлын талаарх төрийн албан хаагчид болон олон нийтийн ойлголт сайжирсан байна.

Үйл ажиллагаа 2.2: Хүүхэд, залуучуудад мэдлэг олгоход чиглэсэн ярилцлага, сургалт зохион байгуулах /Сэдэв: жендэр, хүний эрх, мэргэжил сонголт/ (УБ хотын 14-р сургууль, 4 аймаг бүр 1 сургууль)

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутнуудад хүний эрхийн сургалт зохион байгууллаа

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Дундговь аймаг дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны оюутнуудад "Хүний эрхийн тухай үндсэн ойлголт" сэдэвт 1 цагийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтад нийт 72 оюутан хамрагдаж, үүнээс эрэгтэй 42, эмэгтэй 30 хүүхэд хамрагдлаа.

Сургалтын агуулгын хүрээнд ХЭҮК-ын танилцуулга болон хүний эрхийн зарчмууд, төрийн хүлээх үүрэг, хүний эрхийн хязгаарлалт, хариуцлага, хүний эрхийг хамгаалахад тулгардаг бэрхшээл, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхдээ бодитой хүртээмжтэй нийцтэй байх талаар, Эрүүл мэндээ хамгаалуулах эрх, ХЭҮК-т өргөдөл гомдол хэрхэн шийдвэрлэдэг тухай ойлголтыг хүргэсэн.

Төлөвлөгөөний биелэлт



Зорилт:3. Жендэрийн мэдрэмжтэй бодлого, хөтөлбөрийн баримт бичиг батлагдсан байна.

Үйл ажиллагаа: 3.1. Дотоод журамд дүн шинжилгээ хийх, зохих өөрчлөлтийг оруулах

Дорнод аймаг:Хүний эрхийн үндэсний комисс, Жендэрийн үндэсний хорооны Ажлын албанаас өгсөн зөвлөмжийн дагуу Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4 дэх заалт, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын дагуу Дорнод аймгийн бүх сум, агентлаг, албан байгууллагууд дотоод журмаа шинэчилсэн.

Дээрх ажлыг хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх ажлын үзүүлэлтэд тусгаж, бүтэн 2 сарын хугацаанд хийж гүйцэтгэсэн.

Үр дүн: Дорнод аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч 24 агентлаг, 14 сумын Засаг даргын Тамгын газар, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 8, нийт 46 төрийн байгууллагуудын дотоод журамд өөрчлөлт орсон.

Төлөвлөгөөний биелэлт



Зорилт 3. Жендэрийн мэдрэмжтэй бодлого, хөтөлбөрийн баримт бичиг батлагдсан байна.

Үйл ажиллагаа:3.3. Ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх асуудлыг төрийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусгуулах, түүнд дүн шинжилгээ хийх

Дундговь аймаг: Хөдөлмөрийн мөлжлөг, ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр заалтыг төрийн байгууллагууд хөдөлмөрийн дотоод журамд тусгах чиглэлийг өгч, хэрэгжилтэд хяналт тавьж байгууллагуудаас мэдээлэл авч ажиллалаа. Нийт 25 байгууллага дотоод журамдаа :

- 1.Ажлын байранд бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгах.
2. Бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн сургалт, давтан сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлсэн эсэх заалтуудыг тусгаж хэрэгжилтийг тооцож ажиллалаа.

Бэрхшээл, сургамж


Бэрхшээл:

- КОВИД-19-ийн хязгаарлалт
- Орон нутгийн сонгууль
- 4 аймгийн хамтын ажиллагаа сул
- Цахимаар ажиллах, уулзалт зохион байгуулах

Сургамж:

- ЖҮХ, ХЭҮК-той уялдаа холбоотой ажиллах
- Цахим сургалтын ач холбогдол
- Манлайлагчид маш чухал.
- Гишүүд мэдлэг, мэдээллээ бусаддаа түгээх
- Орон нутгийн болон байгууллага доторх дэд клубын үйл ажиллагааг эрчимжүүлэх
- Гишүүдийн идэвх оролцоог байнга өндөр байлгах арга замыг эрэлхийлэх

Цаашид хийж хэрэгжүүлэх ажил бодлогын хүрээнд: Санал



Gender Mainstreaming & Related Issues

- Цахим уулзалтын хүрээг өргөжүүлэх
- Цахимаар мэдээлэл солилцох
- 2 сар тутамд нэг удаа аль нэг аймгийн гишүүд сар тутмын цахим уулзалтыг гардан зохион байгуулдаг байх /тухайлбал, 2-р сард Дорнод, 4-р сард Дундговь, 6-р сард Сүхбаатар, 8-р сард Төв аймаг гэх мэт/. Тухайн сарынхаа уулзалтын сэдвийг зохион байгуулж буй аймаг өөрөө сонгох
- Бусад саруудад нь төвийн бүсээс нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах
- Төсөл хэрэгждэг аймгуудад жендэрийн аудит хийх

Ингэснээр өөрийн орон нутгийн онцлог, сайн туршлагаа бусадтайгаа хуваалцах боломж бүрдэх.

Төрийн захиргааны төв байгууллагуудын гишүүд ч мөн аймгаасаа суралцах нөхцөл бүрдэх, гишүүдийн идэвх оролцоо сайжрах

Цаашид хийж хэрэгжүүлэх ажил бодлогын хүрээнд: Санал



- Орон нутгийн 4 аймгийн гишүүд маань “Орон нутгийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр” сэдвийн дор мэдээлэл солилцох, харилцан туршлага солилцох уулзалтыг жилдээ 2 удаа зохион байгуулах.
- ЖҮХ-ны хорооны Орон нутаг хариуцсан мэргэжилтнийг урьж оролцуулах, мэргэжил аргазүйн туслалцаа авах
Уг арга хэмжээнд төрийн захиргааны төв байгууллагуудын төлөөллүүдийг нээлттэй оролцуулах.
- Сүхбаатар аймагт дараагийн чуулга уулзалтыг хийх
- Орон нутгийн түвшинд жендэрийн чиглэлээр мэдлэг чадвартай, туршлагатай хүмүүсийг урьж яриа хийлгэх, тэднээс суралцах өглөөний цай, кофе арга хэмжээг хийх

Цаашид хийж хэрэгжүүлэх ажил бодлогын хүрээнд: Санал



- Клубын гишүүдийг сургагч багш нараар сургах, чадавхийг сайжруулах, тэдний оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх
- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр 1 сэдвийн хүрээнд судалгаа хийж, үр дүнг хэлэлцэх цахим уулзалтыг хийх. Үр дүнд суурилсан 1 арга хэмжээг орон нутагт хийж хэрэгжүүлэх / богино хэлбэрийн шторк хийх, баримтат кино хэлбэрт оруулах/
- Бодлогын баримт бичиг жендэрийн мэдрэмжтэй эсэхэд үнэлгээ хийх чадварт сургах



Mongolia:
Enhancing Resource
Management through
Institutional Transformation

Address: Floor 3, National Times News Tower Khudaldaanii gudamj, Khoroo 1
Chingeltei district, Ulaanbaatar-15160 Mongolia

Phone: 7610-5000